

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Малчны тухай хууль нь малчны эрх, үүрэг, малчин өрхийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлдэг суурь хууль юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “мал сүрэг нь үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан нь төрөөс мал аж ахуйн салбарыг зөвхөн үйлдвэрлэлийн салбар бус, үндэсний баялаг, уламжлалт амьдралын хэв маяг, хүнсний аюулгүй байдал, орон нутгийн суурьшлын тулгуур гэж үзэн хамгаалах эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.

Монгол Улсын мал аж ахуйн салбар өнөөдөр нэг талаас үндэсний эдийн засаг, хөдөөгийн хөдөлмөр эрхлэлт, хүнсний хангамжийн чухал тулгуур хэвээр байгаа боловч нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт, зудын давтамж, бэлчээрийн доройтол, залуу малчдын залгамж чанар сулрах зэрэг олон давхар эрсдэлтэй тулгарч байна. Үндэсний статистикийн хорооны 2024 оны мал тооллогын дүнгээр улсын хэмжээнд нийт 57.6 сая толгой мал тоологдсон нь өмнөх оноос 7.0 сая толгой буюу 10.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Мөн 2024 онд нэг малчин өрхөд ногдох малын дундаж тоо 269 толгой болж, өмнөх оноос 40 толгой буюу 12.9 хувиар буурчээ. Малчдын тоо 2024 оны байдлаар 308.7 мянга байгаа боловч энэ үзүүлэлт нь салбарын залгамж чанар баталгаатай байна гэсэн үг биш юм. Харин мал аж ахуй эрхлэх анхан шатны хөрөнгө, өөрийн гэсэн суурь мал, өвөлжөө, хаваржаа, хөдөлмөрийн хэрэгсэл, туршлага, зах зээлд холбогдох боломж дутмаг байгаа нь шинээр өрх тусгаарласан залуу гэр бүл мал аж ахуй эрхлэхэд бодит саад болж байна.

Сүүлийн жилүүдэд тохиолдсон зудын хүндрэл энэ эмзэг байдлыг улам тод харууллаа. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн үнэлгээнд 2023-2024 оны зудын улмаас 8.1 сая орчим толгой мал хорогдсон гэж дурдсан бол ХХААХҮЯ-ны мэдээлэлд 2023 онд 4.9 сая, 2024 онд 9.4 сая толгой мал зүй бусаар хорогдсон талаар тусгасан байна. Энэ нь малчин өрхийн амьжиргаа ганцхан улирлын цаг агаарын эрсдэлээс хамааран огцом доройтох боломжтойг харуулж байгаа үзүүлэлт юм.

Ийм нөхцөлд залуу малчин өрхийг төрөөс дэмжих шаардлага бодитой байгаа боловч уг дэмжлэг нь малын тоог механикаар өсгөх, хавтгайруулсан халамж олгох хэлбэртэй байж болохгүй. Монгол Улсын өмнөх туршлагаас харахад малын тоо толгойг бодлогоор нэмэгдүүлэх нь бэлчээрийн даац, усан хангамж, өвөлжилтийн бэлтгэл, малын чанар, ашиг шимтэй уялдуулахгүй бол байгаль орчны доройтол, зудын эрсдэл, малын ашиг шимийн бууралт, малчин өрхийн орлогын тогтворгүй байдлыг улам нэмэгдүүлж иржээ.

Иймд энэхүү хуулийн төслөөр шинээр гэр бүл болсон малчин залуу өрхөд мал аж ахуйн анхан шатны хөрөнгийг бүрдүүлэх зорилгоор 50 хүртэл толгой бог малтай тэнцэх хэмжээний дэмжлэгийг нэг удаа олгох зохицуулалтыг тусгалаа. Уг дэмжлэг нь нийт малчин өрхөд хавтгайруулан олгох халамж биш бөгөөд зөвхөн тухайн орон нутагт мал аж ахуй эрхлэх бодит боломжтой, шалгуур хангасан, шинээр өрх тусгаарласан залуу малчин гэр бүлд чиглэсэн зорилтот арга хэмжээ юм.

Хуулийн төсөлд дэмжлэгийг бэлчээрийн даацад суурилан олгох, бэлчээрийн даац хэтэрсэн бүс нутагт олгохыг хориглох, мал маллах бодит чадавхыг үнэлэх, чанарын шаардлага хангасан эрүүл малаар олгох, ил тод сонгон шалгаруулалт явуулах, олгосон мал, хөрөнгийг тодорхой хугацаанд бусдад шилжүүлэхийг хориглох,

зориулалтын бусаар ашигласан тохиолдолд буцаан төлүүлэх, дахин төрийн дэмжлэгт хамруулахгүй байх хариуцлагын зохицуулалтыг тусгасан болно.

Олон улсын туршлагаас үзэхэд залуу фермер, залуу малчин, хөдөө аж ахуйн шинэ өрхийг дэмжих бодлого нь дан ганц хөрөнгө олгохоос илүүтэй бизнес төлөвлөгөө, мэргэжлийн ур чадвар, газар болон бэлчээрийн хүртээмж, байгаль орчны шаардлага, санхүүгийн сахилга, хяналттай уялдсан үед илүү үр дүнтэй байдаг. Тухайлбал, Европын Холбооны Хөдөө аж ахуйн бодлогын 2023-2027 оны хүрээнд залуу фермерүүдийг тусгайлан дэмжих бодлого хэрэгжиж, салбарын үе солигдлыг хангах, залуу үйлдвэрлэгчдийг санхүүжилт, мэдлэг, сургалт, зөвлөх үйлчилгээтэй холбохыг зорьж байгааг анзаарч болно. Мөн Монгол Улстай адил нүүдлийн болон бэлчээрийн мал аж ахуйн уламжлалтай Киргиз Улсад Дэлхийн банкны дэмжлэгтэй хэрэгжсэн хөдөө орон нутгийн амьжиргаа, бэлчээрийн менежментийн төсөл нь мал аж ахуйн дэмжлэгийг орон нутгийн бэлчээр ашиглалт, иргэдийн оролцоо, хяналттай уялдуулах нь илүү үр дүнтэй болохыг харуулсан.

Түүнчлэн Монгол Улсад хэрэгжсэн малын индексжүүлсэн даатгалын туршлага нь малчин өрхийн эрсдэлийг зөвхөн зуд тохиолдсоны дараа нөхөх бус, урьдчилан тооцох, даатгах, эрсдэлийг санхүүгийн зохицуулалтаар бууруулах шаардлагатайг харуулсан. Дэлхийн банкны дэмжлэгтэй хэрэгжсэн уг туршлага нь мал аж ахуйн бодлого эрсдэлийн удирдлага, санхүүгийн сахилга, орон нутгийн түвшний мэдээлэлд суурилсан байх ёстойг нотолсон юм

Иймээс энэхүү хуулийн төсөл нь нэг талаас залуу малчин өрхийн үйлдвэрлэлийн эхлэлийг дэмжих, нөгөө талаас малын тоо толгойн өсөлтийг бэлчээрийн даац, малын чанар, орон нутгийн хяналттай уялдуулах замаар хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар залуу малчдын оролцоо нэмэгдэх, шинээр гэр бүл болсон залуу өрх хөдөөд тогтвортой амьдрах эдийн засгийн суурьтай болох, мал аж ахуйн салбарын залгамж чанар бэхжих, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, суурьшил дэмжигдэх эерэг үр нөлөө гарах боломжтой. Үүний зэрэгцээ бэлчээрийн даацад үзүүлэх дарамтыг хяналттай байлгах, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, давхар хүртэлт, зориулалтын бус ашиглалтыг бууруулах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү зохицуулалт нь халамжийн шинжтэй бус, харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуу малчин өрхийн үйлдвэрлэлийн суурийг бүрдүүлэх, хөдөө орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой бодлогын арга хэмжээ юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ